

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 3 сарын 20 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Монгол улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 64 дүгээр зүйлийн 64.2, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 10:00 цагт компанийн ажлын байранд хуралдуулсугай.
2. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай. Үүнд:
  1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;
  2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах;
  3. “Ногдол ашиг хуваарилах тухай” ТУЗ тогтоолыг танилцуулах;
  4. Дүрмийн сан нэмэгдүүлэх тухай хэлэлцэн батлах;
  5. ТУЗ гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь дуусгавар болгох тухай;
  6. Өрийн бичиг гаргах тухай хэлэлцэн батлах;
  7. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв батлах;
  8. Компанийн шинэчилсэн дүрмийг батлах;
  9. Бусад
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 4 дүгээр сарын 10-ний өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбогдуулан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хавсралт №1-ээр “Хурлын дэг”-ийг Хавсралт №2-оор, хувьцаа эзэмшигчдээс авах “Саналын хуудас 1”-ийг Хавсралт №3-аар, “Саналын хуудас 2”-ыг Хавсралт №4-өөр, “Хурлын зар”-ыг Хавсралт №5-аар тус тус баталсугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдахтай холбогдуулан доорх бичиг баримттай 2025 оны 4 дүгээр сарын 24-ны өдрөөс 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 17:00 цаг хүртэл компанийн байранд ирж танилцах эрхтэй болохыг дурдсугай. Үүнд:
  1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол болон тус тогтоолд холбогдох хавсралтуудын хуулбарууд,
  2. Компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн хуулбар
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдлийг хавсралт материалын хамт 2025 оны 3 дугаар сарын 25-ний дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын

Хөрөнгийн бирж ТӨХК-д хүргүүлэх, Хавсралт №5-ын дагуу хурлын зарыг 2025 оны 3 дугаар сарын 29-ний дотор өдөр тутмын 2-оос доошгүй сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг телевиз, Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-д цахим хуудсаар тус тус дамжуулан нийтэд мэдээлэх, 2025 оны 3 дугаар сарын 30-ны дотор брокер дилерийн компанид хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бадамцэцэгт даалгасугай.

7. Саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2025 оны 4 дүтээр сарын 29-ний өдрийн 17:00 цагаар тогтоосугай.
8. Компанийн ээлжит хурлыг удирдан зохион байгуулах комиссын даргаар ТУЗ-ийн дарга Ч.Чинзориг, комиссын гишүүнээр Ч.Тэмүдэр, хурлын нарийн бичгийн даргаар Б.Бадамцэцэг нарыг тус тус томилсугай.
9. Хурлын тооллогын комиссын даргаар В.Шинэбаяр, тооллогын комиссын гишүүнээр Ж.Батбилэг, Ц.Сарангуа нарыг тус тус томилсугай.
10. Хурлын бэлтгэлийг хууль, журмын дагуу сайтар зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  Ч.ЧИНЗОРИГ



# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 3 сарын 20 өдөр

Дугаар 6

Улаанбаатар хот

## КОМПАНИЙН БҮТЭЦ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 заалт, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн бүтэцийг Хавсралт 1-ээр шинэчлэн баталсугай.
2. Компанийн шинэчилсэн бүтцийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, шаардлагатай хүний нөөц, мэргэжилтнийг бүрдүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал Б.Бадамцэцэгт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

*Ч.Чинзориг* Ч.ЧИНЗОРИГ

